

 <p>7</p>	<h1 style="text-align: center;">ЭРХИЙН МЭДЭГДЭЛ</h1> <p style="text-align: center;">Түр саатуулагдсан насанд хүрээгүй хүүхдүүдэд ОЛГОХ (10-13 насны, насанд хүрээгүй хүүхэд )</p>
--	---

**Дор өгөгдсөн мэдээллүүд таны ойлгох хэл дээр өгөгдсөн байх ёстой.**

**Та цагдаад баривчлагдан хоригдох хугацаанд үг баримтыг хадгалж болно.**

Та шоронд 5 жил хүртэлх ял авч хорих ялаар шийтгэгдэж болох гэмт үйлдэл үйлдсэн буюу үйлдэхийг завдсан хэмээх нэг буюу хэд хэдэн сэжиглэх шалтгаан байгааг үндэслэн цагдаа баривчлан хорих болсныг танилцуулсан болно. хэмээх нэг буюу хэд хэдэн сэжиглэх шалтгаан байгааг үндэслэн таныг түр саатуулах болсныг мэдэгдэж байна.

Та өөрийн үйлдсэн ба үүний улмаас хоригдон шалгагдаж байгаа гэмт үйлдлийн зүйлчлэл, огноо ба үйлдсэн газар болон таныг түр саатуулах болсон шалтгааныг мэдэх эрхтэй.

Арван хоёр цаг үргэлжилж болох цагдаад түр саатуулагдсан явцад та уг хэргийн талаар мэдүүлэг өгнө.

Уг хугацаа дууссаны дараа, Улсын Прокурор (эсвэл хяналтын прокурор буюу хүүхдийн шүүгч) таны цагдаад түр саатуулагдсан хугацааг шинээр дахин арван хоёр цагаар сунгаж болно. Та энэ Прокурортой биеэр уулзах боломжгүй бол, видео хурал хийнэ.

Уг түр саатуулагдсаны эцэст, Улсын Прокурор(эсвэл хяналтын прокурор буюу хүүхдийн шүүгч) нарын шийдвэрийн дагуу та нэг бол энэ Прокурортой биечлэн уулзах, нэг бол суллагдана.

**ТАНЫ БУСАД ЭРХИЙГ МЭДЭЭЛЖ БАЙНА :**

**Хэсэг хүмүүст хэлүүлж мэдэгдэх эрхтэй**

Цагдаагийн ажилтан буюу мөрдөн байцаагч таны эцэг эх эсвэл таны асран хамгаалагч, эсвэл таны хариуцагч байгууллагад түр саатуулагдсан талаар хэл мэдүүлнэ.

Хэрэв та гадаадын иргэн бол та өөрийн улсын консулын газарт мэдэгдэж болно. Улсын прокурор (эсвэл ба хүүхдийн шүүгч) байцаалт хийх шалтгаанаар уг өргөдлийг хүлээн авахгүй байх эрхтэй. Онц хүнд байдалд ороогүй л бол, хүсэлттэй танилцаад, 3 цагийн дотор гурван цагийн дотор арга хэмжээ авагдана.

**Эмчээр үзлэг хийлгэх**

Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч) нь танд үзлэг хийх эмчийг тодорхойлно. Түр саатуулагдах хугацаа сунгагдсан тохиолдолд Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч) нь таныг дахин үзэх эмчийг тодорхойлно.

## **Та дуугарахгүй чимээгүй байх эсвэл, эсвэл асуултууданд хариулан байцаалтаа өгч болно**

Та өөрийн биеийн байцаалтаа хэлсний дараа байцаалт өгөхдөө доорхи эрхийг эдэлнэ:

- мэдүүлгээ өгөх,
- Танаас асуусан асуултууданд хариулах,
- үг дуугарахгүй байх.

### **Өмгөөлөгчийн туслалцаа авах**

#### **- Өмгөөлөгч сонгох**

Түр саатуулагдах хугацааны эхэнд, хэрэв саатуулагдах хугацаа сунгагдсан тохиолдолд, сунгасан хугацааны эхэнд та өөрийн сонгосон өмгөөлөгчийн туслалцаа авах хүсэлт гаргах эрхтэй. Та өөрөө өмгөөлөгчөө сонгох боломжгүй эсвэл таны өмгөөлөгчтэй холбогдох боломжгүй бол улсаас танд үнэгүй туслалцаа үзүүлэхээр томилсон өмгөөлөгчийг авах хүсэлт тавих эрхтэй.

Таны өмгөөлөгчийг таны эцэг эх эсвэл таны, асран хамгаалагч эсвэл таныг хариуцсан байгууллага сонгож болно.

Боломжгүй бол, байцаагч Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч) нь улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгч авах хүсэлтийг гаргаж болно.

#### **- Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцооны хугацаа**

Өмгөөлөгч:

- ярилцлагын нууц байдлыг чанд хадгалсан нөхцөлд таньтай 30 минут ярилцана,
- таны байцаалт болон нүүрэлдүүлэхэд оролцоно.

Таны хүсэлтийг өмгөөлөгчид явуулсан бол шүүх хурал хоёр цагийн дотор таны 1-<sup>p</sup> байцаалт таны өмгөөлөгчийн байхгүй тохиолдолд эхлэх есгүй, зөвхөн таны биеийн байцаалтан талаар мэдүүлэг авч л болно. Гэвч, мөрдөн байцаалтын хэрэгцээ шаардлагын дагуу таны 1-р[3] байцаалт Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч)-ийн зөвшөөрлөөр өмгөөлөгч байлцаагүй үед ч нэн даруй эхэлж болно.

Нүүрэлдүүлэх буюу байцаалтын явцад таны өмгөөлөгч хүрэлцэн ирсэн тохиолдолд таны хүсэлтээр байцаалтыг өмгөөлөгчтэй ярилцах боломж олгон түр завсарлуулж болно.

Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч) ба Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч нар хүндэтгэх шалтгаан болон онцгой тохиолдолд байцаалтын үе дэх таны өмгөөлөгчийн туслалцааг 12 цагийн турш хойшлуулах эрхтэй, энэ нь нэг удаа шинэчлэгдэж болно.

### **Хэлмэрчийн туслалцаа**

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

### **Түр саатуулалтыг төгсгөл болгохыг хүсэх эрх**

Та Улсын Прокуророос, хяналтын прокурор эсвэл хүүхдийн шүүгчээс шүүх түр саатуулах хугацааг сунгах шийдвэр гаргасан байвал түүнийг дахин сунгахгүй талаар хүсэлт тавих эрхтэй.

### **Таны хавтаст хэргийн зарим материалд хүрэх боломж**

Та буюу таны өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан та түр саатуулах хугацаа сунгахын өмнө доорхи зүйлсийг шаардан харах эрхтэй:

- таны саатуулагдаж буйг мэдэгдсэн протокол,
- танд үзлэг хийсэн эмчийн эмнэлгийн тодорхойлолтуудтай танилцах,
- танаас авсан байцаалтуудын протоколтой танилцах.

**Үйл ажиллагааны цаашдын явцын талаа мэдээлэл олгох**

Түр саатуулах явц дууссаны дараа хэрэв Улсын прокурор (эсвэл хяналтын прокурор ба хүүхдийн шүүгч) нар ямар нэгэн шийдвэр гаргаагүй тохиолдолд та 6 сар өнгөрмөгц Улсын прокуророос энэ хэргийн үйл явцын талаар тайлбар гаргахыг хүсэн цаашдын авах арга хэмжээг мэдэх эрхтэй.